

АЛБАН ТУШААЛТАН ӨӨРТ НОГДУУЛСАН САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН  
ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙГ ХОЛБОГДОХ ЭТГЭЭД БОЛОН НИЙТЭД ӨӨРИЙН  
ЗАРДЛААР ХҮРГЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖУРАМ

*Нэг. Ерөнхий зүйл*

1.1. Энэхүү журмаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /цаашид “Хууль” гэх/-ийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан нийтийн албан тушаалтанд хүлээлгэсэн сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг албан тушаалтан холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журмыг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан нийтийн албан тушаалтан, мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэгт дурдсан сахилгын шийтгэл хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан дагаж мөрдөнө.

1.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд хүргэхтэй холбогдон гарах зардлыг сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтан хариуцна.

1.4. Сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай мэдээллийг бэлтгэх, холбогдох этгээд хүргэх, нийтэд мэдээлэх үүргийг сахилгын шийтгэл ногдуулах шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан өөрийн байгууллагын Тамгын газар буюу Захиргааны хэлтэс /нэгж/-т хариуцуулна.

1.5. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх болон нийтэд мэдээлэхтэй холбогдон гарах зардлыг сахилгын шийтгэл хүлээсэн албан тушаалтнаас гаргуулан авах үүргийг энэ журмын 1.4-т дурдсан газар, хэлтэс/нэгж/-ийн дарга хариуцан гүйцэтгэнэ.

1.6. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг уг шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор холбогдох этгээдэд хүргэж, нийтэд мэдээлнэ. Мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээллэхэд тухайн албан тушаалтнаас зөвшөөрөл авсан байхыг шаардахгүй.

*Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт*

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "холбогдох этгээд" гэж хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан сахилгын шийтгэл хүлээлгэх зөрчлийн талаар мэдээлэгч, гомдол гаргагч, нийтийн албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас эрх ашиг нь хөндөгдсөн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллагыг;

2.1.2. “эрх бүхий албан тушаалтан” гэж Нийтийн албан тушаалтанд хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасан сахилгын шийтгэл хүлээлгэх эрх бүхий этгээдийг;

2.1.3. “зардал” гэж сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэхтэй холбогдон гарах шуудан, холбооны болон хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтлэх, цахим сүлжээнд байршуулах зэрэгт зарцуулах үйлчилгээний үнэ, хөлсийг.

#### *Гурав. Холбогдох этгээдэд хүргэх*

3.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг мэдээлэгч, гомдол гаргагч, нийтийн албан тушаалтны хууль зөрчсөн үйл ажиллагааны улмаас эрх ашиг нь хөндөгдсөн иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага болон тухайн албан тушаалтны харъяалах дээд шатны байгууллагын удирдлагад албан бичгээр хүргүүлнэ.

3.2. Харъяалах дээд шатны байгууллагын удирдлагад хүргүүлэх албан бичигт сахилгын шийтгэл хүлээлгэсэн шийдвэрийн хуулбарыг хавсаргана.

3.3. Хуулиар хязгаарласан болон хориглосон хэм хэмжээг зөрчихгүй байх, ашиг сонирхлын зөрчил дахин гарахаас урьдчилан сэргийлэх зорилгоор албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай шийдвэрийг байгууллагын нийт албан хаагчдад уншиж танилцуулна.

#### *Дөрөв. Нийтэд мэдээлэх*

4.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг дараахь хэлбэрээр нийтэд мэдээлнэ.

4.1.1. Өдөр тутмын сонинд нийтлүүлэх;

4.1.2. Харъяалах байгууллагын цахим хуудсанд нийтлэх;

4.1.3. Мэдээллийн самбарт байршуулах.

4.2. Нийтэд хүргэх мэдээлэлд сахилгын шийтгэл хүлээсэн этгээдийн овог, нэр, байгууллагын нэр, албан тушаал, сахилгын шийтгэл хүлээлгэсэн үндэслэл, сахилгын шийтгэлийн төрөл, холбогдох этгээдэд мэдэгдсэн болон нийтэд мэдээлсэн хэлбэр, хугацааг тусгана.

4.3. Албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэсэн талаарх мэдээллийг энэхүү журмын 4.1-д заасан хэлбэрээр хүргэх үүргийг журмын 1.4-т дурьдсан газар, хэлтэс /нэгж/-ийн хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан хариуцан гүйцэтгэнэ.

#### *Тав. Бусад зүйл*

5.1. Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор журмын 4.2-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийн хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ. Мэдээллийг цахим хэлбэрээр хүргүүлж болно.

5.2. Авлигатай тэмцэх газар эрх бүхий албан тушаалтнуудаас ирүүлсэн мэдээлэл, шийдвэрийг хүлээн авч, нэгдсэн сан бүрдүүлэн ажиллана. Сан нь олон нийтэд нээлттэй байна.

5.3. Албан тушаалтанд ногдуулсан сахилгын шийтгэл нь шүүхийн шийдвэрээр үндэслэлгүй болох нь тогтоогдсон, эсхүл сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа

дууссан бол энэ тухай нотолгоо бүхий хүсэлтийг санд өөрчлөлт оруулах саналын хамт Авлигатай тэмцэх газарт хүргүүлнэ.

5.4. Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаар холбогдох этгээдэд хүргэх, нийтэд мэдээлэхтэй холбоотой зардлыг гаргаагүй нь мэдээлэл хүргэх, нийтэд мэдээлэхээс татгалзах үндэслэл болохгүй.

5.5. Энэхүү журмын заалтыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

...o0o...